




**УЛААНБААТАР ХОТ,  
БНХАУ-ЫН ЗАРИМ ХОТЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА**

**2022 оны 06 дугаар сарын 21**

**Нийслэлийн Бодлогын судалгаа,  
шинжилгээний төвийн захирал  
А.Мөнхболд Ph.D, дэд профессор**



# НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



## **Оросын Холбооны Улс**

- Москва (1957)
- Эрхүү (1996)
- Элстэй (2010)
- Новосибирск (2015)

## **Америкийн Нэгдсэн Улс**

- Денвер (2001)
- Оакланд (2006)

## **Бүгд Найрамдах Турк Улс**

- Анкара (2003),
- Газиантеп (2010)

## **Бүгд Найрамдах Куба Улс**

- Хавана (2002)

## **Тайландын Хаант Улс**

- Бангкок (2017)

## **Бүгд Найрамдах Казахстан Улс**

- Нур- Султан (2019)

## **Бүгд Найрамдах Хятад Ард Улс**

- Бээжин (2014)
- Хөх хот (1991)
- Чунчин (1999)

## **Бүгд Найрамдах Солонгос Улс**

- Сөүл (1995)
- Инчеон (2017)



Ах дүүгийн харилцаатай – 16  
Найрсаг харилцаатай – 28




# БЭЭЖИН ХОТ



*“Өнөөгийн Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэн дэлгэгдэв.*

*Бээжин хот 2018.10.25*



*Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жил, Улаанбаатар, Бээжин хотууд найрамдалт харилцаа тогтоосны 5 жилийн ойн хурээнд “Бээжин хотын өдрүүд” арга хэмжээг зохион байгууллаа.*

*Улаанбаатар хот 2019.07.20*



# УЛААНБААТАР, БЭЭЖИН ХОТ ХООРОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЦЛОГ АРГА ХЭМЖЭЭ:



- ✓ Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны Хот тохижуулах газар, БНХАУ-ын Бээжин үндэстний соёл, эдийн засгийг хөгжүүлэх төв компанийн хооронд **1990 оны зургаадугаар сарын 13-нд** “Хамтран ажиллах тухай Санамж бичиг” байгуулжээ.
- ✓ Бээжин хотын Ардын Засгийн газрын урилгаар Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны тэргүүн дэд дарга Г.Ганхуяг нарын төлөөлөгчид **1991 оны тавдугаар сарын 24-31-нд Бээжин хотод** албан айлчлал хийж, Бээжин хотын дарга Чэнь Шитунтай уулзсан .
- ✓ БНХАУ-ын Зам гүүрний корпорацийн төлөөлөгчид **2009 оны хоёрдугаар сарын 17-20-нд Улаанбаатар хотноо** ирж, авто замын нөхцөл байдалтай танилцан, цаашид хотын авто замын сүлжээг боловсронгуй болгоход Нийслэлийн Авто замын газар, “МОНРЕ” ХХК-тай хамтран ажиллахаар тохиролцсон юм.
- ✓ НИТХ-ын дарга Т.Билэгт, БНХАУ-ын Зам гүүрний корпорацийн дэд ерөнхийлөгч Вэн Ган нар **2009 оны гуравдугаар сарын 10-нд Бээжин хотноо** Улаанбаатар хотын зам, гүүрний барилгажилтад хамтран ажиллахаар “Хамтын ажиллагааны Санамж бичиг”-т гарын үсэг зурлаа.
- ✓ Бээжин хотын Боловсролын хорооны төлөөлөгчид **2014 оны тавдугаар сарын 21-23-нд** Улаанбаатар хотод зочилж, хоёр хотын боловсролын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр “Хамтын ажиллагааны Санамж бичиг”-ийг үзэглэсэн байна.
- ✓ НИТХ-ын дарга Д.Баттулга тэргүүтэй төлөөлөгчид **2015 оны тавдугаар сарын 12-14-нд Бээжин хотод** албан айлчлал хийлээ. НИТХ-ын даргын анхны айлчлал хоёр хотын хурал хоорондын хамтын ажиллагааг нээсэн түүхэн ач холбогдолтой айлчлал болж байгааг хоёр тал онцлон тэмдэглэв. Айлчлалын хүрээнд Бээжин дэх Монгол Улсын Элчин сайдын яам, Бээжин хотын Ардын Засгийн газартай хамтран “Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлт ба хөрөнгө оруулалт 2015” ажил хэргийн уулзалтыг зохион байгуулсан.
- ✓ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд **2018 оны 10 дугаар сарын 22-нд Бээжин хотноо** албан ёсны айлчлал хийж, “Улаанбаатар хотын өдрүүд” арга хэмжээний хүрээнд анх удаа тус хотноо “Улаанбаатар хөрөнгө оруулалт-2018” бизнес уулзалт, “Улаанбаатарын үдэш” урлагийн тоглолт болон “Өнөөгийн Улаанбаатар” гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан.
- ✓ НЗДТГ болон Бээжин хотын Ардын Засгийн газар хамтран **2019 оны долдугаар сарын 19-20-нд Улаанбаатар хотноо** “Бээжин хотын өдрүүд” арга хэмжээг зохион байгууллаа.
- ✓ Бээжин хотын Намын хорооны нарийн бичгийн даргын орлогч Ли Биюу тэргүүтэй албаны болон соёл урлагийн 60 гаруй төлөөлөгч Улаанбаатар хотод айлчилсан билээ. Айлчлалын үеэр нийслэлийн Чингэлтэй дүүрэг, Бээжин хотын Шичөн дүүргүүд Найрсаг хамтын ажиллагааны тухай Санамж бичигт гарын үсэг зурснаас гадна Бээжин хотын урлаг, соёлын төлөөлөгчид урлагийн тоглолт, биет бус соёлын өвийн үзэсгэлэн болон эко ногоон гэрэлтүүлгийн үзэсгэлэнг нийслэлчүүдэд бэлтгэн хүргэсэн юм.

# ТЯНЬЖИН ХОТ



*Нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан  
БНХАУ-ын Тяньжин хотын төлөөлөгчидийг хүлээн авч уулзлаа.*

*Улаанбаатар хот 2019.01.24*



# УЛААНБААТАР, ТЯНЬЖИН ХОТ ХООРОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЦЛОГ АРГА ХЭМЖЭЭ:



- ✓ “Улаанбаатар, Тяньжин хотын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээр”-т **1992 оны есдүгээр сард** гарын үсэг зурснаар хоёр хотын харилцааны түүх эхэлсэн байна.
- ✓ Тяньжин хотын дарга Ли Шэнлигийн урилгаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч М.Энхболд тэргүүтэй төлөөлөгчид **1999 онд Тяньжин** хотноо албан ёсны айлчлал хийж, “Улаанбаатар, Тяньжин хотын хоорондын хамтын ажиллагааны тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурсан байна. Санамж бичигт нутгийн захиргаа, эдийн засаг, хөдөө аж ахуй, соёл, боловсролын салбарт туршлага солилцож, төр, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийг хамарсан хамтын ажиллагааг хөгжүүлэх тухай заалтууд тусгагджээ.
- ✓ НЗДТГ-ын Гадаад харилцааны хэлтсийн дарга Э.Амарсанаа, Тяньжин хотын Ардын Засгийн газрын Гадаад харилцааны газрын дарга Тиэн Гүймэн нар **2010 оны долдугаар сарын 28-нд** Улаанбаатар хотод “Улаанбаатар хот, Тяньжин хотын эдийн засаг, хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Санамж бичиг”-т гарын үсэг зурав.
- ✓ Тяньжин хотын Намын хорооны байнгын хорооны гишүүн Жан Сианфу тэргүүтэй төлөөлөгчид **2014 оны есдүгээр сарын 23-26-нд Улаанбаатар** хотод айлчилж, Эдийн засгийн хөгжлийн яам, Авлигатай тэмцэх газар болон нийслэлийн удирдлагатай уулзаж, талуудын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.
- ✓ Тяньжин хотын Намын хорооны дарга Ли Хунжун **2018 оны аравдугаар сард** БНХАУ-ын Коммунист намын төлөөлөгчдийг ахалж, Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн бөгөөд тус айлчлалын үеэр Монгол Улстай хэрэгжүүлэх **10 бодит ажлыг** санаачиллаа.
- ✓ Тяньжин хотын Олон улсын худалдаа, далайн тээврийн үйлчилгээний төвийн дарга Цао Жүнь нарын төлөөлөгчид **2019 оны нэгдүгээр сард Улаанбаатар хотноо** зочилж, Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалантай уулзав. Талууд **Тяньжин боомтын Худалдааны төлөөлөгчийн газар, Нэг цэгийн үйлчилгээний газрыг Улаанбаатар хотод** байгуулж хамтран ажиллах асуудлаар харилцан санал солилцлоо.

# ХӨХ ХОТ



*Улаанбаатар хот Хөх хоттой ах дүүгийн харилцаа тогтоосны 30 жилийн ойн арга хэмжээ.*

*Улаанбаатар хот 2021.12.10*



# УЛААНБААТАР, ХӨХ ХОТ ХООРОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ОНЦЛОГ АРГА ХЭМЖЭЭ:



- ✓ Улаанбаатар, Хөх хотын хооронд анх **1991 онд** Ах дүү хотын харилцаа тогтоох тухай албан ёсны баримт бичигт гарын үсэг зурсан.
- ✓ Ах дүүгийн харилцаа тогтоосны 10 жилийн ойг **2001 онд талууд** хамтран тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ үеэр **Улаанбаатар хотод “Хөх хотын өдрүүд”** арга хэмжээг хамтран зохион байгуулав.
- ✓ Хөх хотын орлогч дарга Ван Суй тэргүүтэй төлөөлөгчид **2002 оны 10 сарын 24-30-нд Улаанбаатар хотод айлчилсан**. Хоёр хотын дүүргүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын есөн дүүрэг, Хөх хотын есөн дүүрэг, засаг захиргааны нэгжүүд шууд харилцаа тогтоон, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг эрчимжүүллээ.
- ✓ **Хөх хотын Ардын Засгийн газрын дарга Тан Айжунь** тэргүүтэй төлөөлөгчид **2006 оны есдүгээр сард Улаанбаатар хотод** айлчилж, талууд **Ах дүүгийн харилцаа тогтоосны 15 жилийн ойг** хамтран тэмдэглэлээ. Айлчлалын үеэр **“Сурагч солилцооны хөтөлбөр”**-ийг хэрэгжүүлэхээр тохиролцсон.
- ✓ Нийслэлийн Захирагчийн ажлын албаны дарга бөгөөд Улаанбаатар хотын Ерөнхий менежер Ч.Бат тэргүүтэй **төлөөлөгчид 2008 оны 9 сард “Хятадын бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа”** арга хэмжээнд оролцож, хоёр хотын Эрүүл мэндийн газрууд Хамтран ажиллах гэрээг үзэглэжээ.
- ✓ Хөх хотын Ардын Засгийн газрын Тэргүүн зэргийн зөвлөх Хан Жиран тэргүүтэй төлөөлөгчид **2009 оны 10 сарын 27-ноос 11 сарын 3-нд Улаанбаатар хот** үүсэн байгуулагдсаны 370 жилийн ойн баяраар, **Сайхан дүүрэг, Чингэлтэй дүүргийн хооронд хамтын ажиллагааны санамж бичиг** тус тус байгуулсан.
- ✓ **2010 оны есдүгээр сарын 6-10-нд** Хоёр хотын харилцаа, хамтын ажиллагааг өндрөөр үнэлж, Хөх хотын Ардын Засгийн газраас Улаанбаатар хотыг **“Хятадтай найрамдалт харилцаатай хот”**-ын шагналаар шагнасан.
- ✓ **“Хөх хотын өдрүүд”** арга хэмжээг **2012 оны есдүгээр сарын 17-22-нд Улаанбаатар** хотноо зохион байгууллаа. Хөх хотын дарга Чэн И тэргүүтэй төлөөлөгчид хүрэлцэн ирж, тус арга хэмжээнд оролцсон.
- ✓ Монгол Улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойг тохиолдуулж, Хөх хотын Улс төрийн зөвлөлдөх хорооны орлогч дарга Юнь Күй тэргүүтэй төлөөлөгчид **2019.6 сарын 27-07.1-нд Улаанбаатар хотод** айлчилж, **“Хөх хотын өдрүүд арга хэмжээ”**-г зохион байгуулав.
- ✓ Ах дүү хотын харилцаа тогтоосны 30 жилийн ойг хамтран тэмдэглэх зорилгоор талууд **2021 оны 12 сарын 10-нд** ойн арга хэмжээг цахим хэлбэрээр зохион байгуулж, танхим, хороод, хоёр хотын аж ахуйн нэгжүүд бизнес уулзалтын хүрээнд хамтран ажиллах асуудлаар санал солилцож, **“Хамтран ажиллах тухай санамж бичиг”**-ийг тус тус байгуулсан.



# ЧӨНДҮ ХОТ



*Улаанбаатар-Чөндү хотуудын хооронд найрамдалт харилцаа тогтоох санамж бичиг байгуулав.*

*Улаанбаатар хот 2019 он*



# ЧУНЧИН ХОТ



*Улаанбаатар Чунчин хоттой Ах дүү хотын харилцаа тогтоов.*

*Улаанбаатар хот 2022.05.12*



# ХЯТАДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ:



- ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ОЙРОЛЦООХ ГҮҮРЭН ГАРЦ БАРИХ ТӨСӨЛ - **93%**
- ГАЧУУРТЫН УУЛЗВАРААС НАЛАЙХ-ЧОЙРЫН УУЛЗВАР ХҮРТЭЛХ 20.9 КМ АВТО ЗАМЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛТИЙН ТӨСӨЛ - **98%**
- ТУУЛ ГОЛ ДЭЭГҮҮРХ БАЯНЗҮРХИЙН 321 У/М БОЛОН СОНСГОЛОНГИЙН 289.4 У/М ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙГ ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ - **100%**
- “ЯАРМАГИЙН ШИНЭ ГҮҮР БАРИХ, ХУУЧИН ГҮҮРИЙГ ЗАСВАРЛАХ ТӨСӨЛ” - **100%**



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

# ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ОЙРОЛЦООХ ГҮҮРЭН ГАРЦ БАРИХ ТӨСӨЛ



**USD 42.4 сая**

БНХАУ-ын Засгийн газрын  
Хөнгөлөлттэй зээл



УЛААНБААТАР ХОТ,  
СБД, БЗД



2017-2022

**ТӨСЛИЙН ЗОРИЛГО:** Улаанбаатар хотын төвд төмөр зам болон авто замын уулзвар дээгүүр олон түвшний огтлолцол барьж, авто зам болон төмөр замын хөдөлгөөнийг тусгаарлаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулж, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖИЛ:

- 477 у/м, 4 эгнээ, шинэ гүүрэн гарц (төмөр зам, Нарны зам дээгүүр)
- 276 у/м, 1 эгнээ гүүрэн зам, А-рамп
- 218,5 у/м, 1 эгнээ гүүрэн зам, С-рамп
- 337 у/м, 1 эгнээ гүүрэн зам, В-рамп
- 66 у/м, 1 эгнээ гүүр, 2 ш гүүр Дунд гол дээгүүр
- Авто зам, борооны ус зайлуулах байгууламж
- Явган хүний гүүр, гэрэлтүүлэг, ногоон байгууламж
- Инженерийн шугам сүлжээний ажил /цахилгаан, холбоо, цэвэр ба бохир ус, дулаан /

**Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 93%**

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД:

- Зураг төсөл боловсруулах – 1.03 сая ам.доллар – **2.5%**
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх – 35.82 сая ам.доллар – **82.5%**
- Магадлашгүй ажил, үнийн магадлашгүй зардал – 5.52 сая ам.доллар – **15%**

**НИЙТ ХИЙГДСЭН АЖИЛ:** Үндсэн гүүр, А, В, С рамп гүүр, Дунд голын зүүн болон баруун талын гүүр, үндсэн гүүр болон В рампын гэрэлтүүлэг, Олимпийн гудамжны баруун талын туслах зам, Нарны замын Соёлжийн нүхэн гарцаас үндсэн гүүр хүртэлх зүүн хэсгийн авто зам болон Нарны замын хойд урсгалын авто замын хучилт болон төлсийн хүрээнд инженерийн шугам сүлжээний ажлууд хийгдсэн. Явган хүний гүүрэн гарцын барилга, угсралтын ажил, Нарны зам, Олимпийн гудамжны зүүн талын туслах замын борооны ус зайлуулах байгууламж, явган замын барилга угсралтын ажил, гэрэлтүүлгийн үлдэгдэл ажил, ногоон байгууламжийн ажлууд үргэлжилж байна.

**2022 ОНД ХИЙХ АЖИЛ:** Олимпийн гудамжны зүүн талын туслах зам, А рампын холбоос зам, үндсэн гүүрийн доогурух буцах рэгэлтийн туслах зам, явган зам, Нарны замын баруун хэсгийн урд талын зорчих хэсгийн асфальбетон хучилт, явган хүний гүүр, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэж дуусган, төслийн ажлыг ашиглалтад хүлээлгэн өгнө.







НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

# ГАЧУУРТЫН УУЛЗВАРААС НАЛАЙХ-ЧОЙРЫН УУЛЗВАР ХҮРТЭЛХ 20.9 КМ АВТО ЗАМЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛТИЙН ТӨСӨЛ



**USD 36.5 сая**

БНХАУ-ын Засгийн газрын  
Хөнгөлөлттэй зээл 95%, 5% МУ-ын  
Засгийн газрын хариуцах хөрөнгө



УЛААНБААТАР ХОТ,  
БЗД, НД



2018-2022

## ТӨСЛИЙН ЗОРИЛГО:

Улс, Нийслэлийн авто замын сүлжээг хөгжүүлж, баригдсанаасаа хойш 60 жил болсон, бүтцийн эвдрэлд орсон 2 эгнээ авто замыг 4 эгнээ болгон өртгөтгөж, хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах .

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖИЛ:

- Авто замын урт 20,9км, авто замын зорчих хэсгийн өргөн 25.5м, эгнээний өргөн 3.75м, хөвөө 2x0,5м
- 1 ш 20.75 у/м гүүр /Хөлийн гол/
- 3 ш нүхэн гарц- /Богд уулын арын зам 32 у/м, мал, амьтны гарц 40 у/м, Тэрэлжийн уулзвар 29.6 у/м /
- Ус зайлуулах хоолой 38 байршилд
- Явган хүний гүүр 5 байршилд, явган хүний зам 2x1.5 болон дугуйн зам 2x1.2м-ыг суурьшлын бүс дагуу 5.1 км-т
- Гэрэлтүүлэг /нийт авто замын дагуу/
- Инженерийн шугам сүлжээний шилжүүлгийн ажил /цахилгаан, холбоо, бохир усны шугам/

**Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 98%**

## БҮРЭЛДЭХҮҮН АЖЛУУД:

1. Барилгын ажил – 33.21 сая ам.доллар, **90%**
2. Барилгын магадлашгүй ажил болон үнийн магадлашгүй зардал – 3.3 сая ам.доллар, **10%**

## НИЙТ ХИЙГДСЭН АЖИЛ:

4 эгнээ авто замын далан, суурь, асфальтобетон суурь болон өнгө хучилт, Хөлийн голын гүүр, 38 байршилд борооны ус зайлуулах хоолой, 3 байршилд нүхэн гарц, 5.01 км явган хүний зам, явган замын хайс, нийт замын дагуу гэрэлтүүлгийн ажил, авто замын тусгаарлах хашлага, гялбаанаас хамгаалах тоноглол, Налайх-Чойрын уулзварын өөрчлөлт, 52 км туузан хашлага, тэмдэг, тэмдэглэгээний ажлууд 2019-2021 оны хооронд хийгдсэн. 2022 онд авто замын далан хөвөө, ус зайлуулах хоолойн чулуун бэхэлгээ, туузан хашлага, тэмдэг тэмдэглэгээний үлдэгдэл ажлыг гүйцээх, засвар, цэвэрлэгээ хийж, нүхэн гарцын далангийн зүлэгжүүлэлт, 4 буцах эргэлтийн замын дундах талбай асфальтобетон хучилтын ажил, 1 ш гэрлэн дохио суурилуулах, уулзварын өргөсөлт, 2 ш нүхэн гарцын өндрийн хязгаарлалт суурилуулах ажлууд хийгдэж дууссан. Явган хүний гүүрэн гарцын зураг төсөв магадлалаар эцэслэн батлагдсан.

**ТӨСЛИЙН 2022 ОНД ХИЙХ АЖИЛ:** Авто замын далан хөвөө, ус зайлуулах хоолойн чулуун бэхэлгээ засах, тэгшлэх, туузан хашлага, тэмдэг тэмдэглэгээний засвар, цэвэрлэгээ, нүхэн гарцын өндрийн хязгаар зэрэг тоноглолын ажлууд хийгдэнэ. Явган хүний гүүрэн гарц болон гэрлэн дохио суурилуулах ажил гүйцэтгэж дууссан төслийн ажлыг ашиглалтад өгнө.





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

# ТУУЛ ГОЛ ДЭЭГҮҮРХ БАЯНЗҮРХИЙН 321 У/М БОЛОН СОНСГОЛОНГИЙН 289.4 У/М ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙГ ШИНЭЭР БАРИХ ТӨСӨЛ



**USD 21.4 сая**

БНХАУ-ын Засгийн газрын  
Хөнгөлөлттэй зээл, 100%



УЛААНБААТАР ХОТ,  
СХД, БЗД



2018-2020

**ТӨСЛИЙН ЗОРИЛГО:** Улаанбаатар хотын төвд төмөр зам болон авто замын уулзвар дээгүүр олон түвшний огтлолцол барьж, авто зам болон төмөр замын хөдөлгөөнийг тусгаарлаж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулж, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах.

**ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖИЛ:** Баянзүрхийн гүүр 281.2у/м, 22.6м өргөн, 4 эгнээ хайрцган дам нуруутай, төмөрбетон гүүр, явган замтай шинэ гүүр болон үерийн хамгаалалтын далан барих, Сонсголонгийн гүүр 289.4 у/м, 21.9м өргөнтэй, явган замтай, 2 эгнээ зорчих хэсэг бүхий төмөрбетон шинэ гүүр барих, хуучин гүүрийг засварлах, гэрэлтүүлэг хийгдэнэ.



## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД:

Барилын угсралтын ажил – 20.33 сая ам.доллар, - **95.5%**

- Баянзүрхийн 321у/м 4 эгнээ шинэ гүүр барих: 13.85 сая ам.доллар – 68.1%
- Сонсголонгийн 289.4 у/м шинэ гүүр барих: 3.55 сая ам.доллар – 17.5%
- Сонсголонгийн хуучин гүүрийн засвар: 0.78 сая ам.доллар – 4.4%

Магадалшгүй ажил болон үнийн магадалшгүй зардал – 2.1 сая ам.доллар- 10%– 2.1 сая ам.доллар- 10%

Зөвлөх үйлчилгээ – 1.04 сая ам.доллар, **4.5%**

**ТӨСЛИЙН 2022 ОНД ХИЙХ АЖИЛ:** Баянзүрхийн гүрийн үерийн хамгаалалтын далангийн ажил, гүүрийн явган хүний замын бетон цутгалт, гүүрийн явган хүний замын 4 төгсгөлд 4 шат барих ажил, голын урсгал сэргээх, захын тулгуурын конусан далангийн өрлөгийн ажил, үерээс хамгаалах далангийн ажлуудыг гүйцэтгэж, кемпийн талбайн нөхөн сэргээлт, зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн барилгын ажил бүрэн дууссан.

**НИЙТ ХИЙГДСЭН АЖИЛ:** Сонсголонгийн шинэ гүүрийг 2019 оны 7 дугаар сарын 05-ны өдөр, хуучин гүүрийн засварын ажлыг дуусгаж 2019 оны 9 дүгээр сарын 20-ний өдөр хөдөлгөөн нээсэн. Сонсголонгийн гүүрийн ажил 100% дуус ч, 2019 оны 11 дүгээр сарын 28-ний өдөр ашиглалтад өгсөн. Баянзүрхийн гүүрийн барилгын үндсэн ажил дуус ч, 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Налайхын авто замын хамт зорчих хэсгийн хөдөлгөөнийг нээсэн ба үерийн хамгаалалтын далан, нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэж дуусган 2021 оны 8-р сард ашиглалтад авах комисс ажиллаж, хүлээн авсан.

**Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 100%**





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗАР

# “ЯАРМАГИЙН ШИНЭ ГҮҮР БАРИХ, ХУУЧИН ГҮҮРИЙГ ЗАСВАРЛАХ ТӨСӨЛ”



**USD 30.3 сая**

БНХАУ-ын Засгийн газрын  
Хөнгөлөлттэй зээл



УЛААНБААТАР ХОТ,  
ХУД



2016-2020

**ТӨСЛИЙН ЗОРИЛГО:** Улаанбаатар хотын авто замын сүлжээг өргөтгөж, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулж, замын хөдөлгөөний түгжрэл, агаарын бохирдлыг бууруулах.

## ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙХ АЖИЛ:

Дараах ажлуудын зураг төсөл болон барилгын ажил

- 250 у/м, 4 эгнээ гүүр
- 52 у/м нүхэн гарц
- 276 у/м, 8.5 м өргөн, D-рамп,
- 255 у/м, 2 эгнээ бүхий хуучин гүүр засварлах
- Туслах авто зам, явган хүний зам
- Борооны ус зайлуулах байгууламж
- Гэрэлтүүлэг
- Ногоон байгууламж
- Инженерийн шугам сүлжээний ажил /цахилгаан, холбоо, цэвэр ба бохир ус, дулаан /

**Нийт ажлын гүйцэтгэлийн хувь: 100%**

## БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД:

1. Зураг төсөл боловсруулах – 0.85 сая ам.доллар, **100%**
2. Барилга угсралтын ажил гүйцэтгэх – 25.5 сая ам.доллар, **100%**
3. Магадалшгүй зардал (2 төрөл) – 3.95 сая ам.доллар, **0%**


**2020 ОНД ХИЙСЭН АЖИЛ:** Хилийн боомтыг түр хааж, зорчигчдын нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарласантай холбогдуулан гүйцэтгэгчийн ИТА, ажиллах хүч хугацаа хойшлогдож, холбогдох зөвшөөрлийн дагуу удирдлага, ИТА ирснээр 2020.09.12-ны өдрөөс 2019.12.04-ний өдөр ажилласан Улсын комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, комиссын актыг эцэслэн баталгаажуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

## НИЙТ ХИЙГДСЭН АЖИЛ:

- 250у/м, 4 эгнээ шинэ гүүр
- 52 у/м жаазан гүүр болон U суваг
- 276 у/м D рамп гүүр, /Богд уулын арын замыг Наадамчдын замтай холбох/
- 3.8 км авто зам, тэмдэг тэмдэглэгээ, тоноглол
- 255.4 у/м хуучин гүүрийн засвар
- Гэрэлтүүлэг
- Цахилгаан, холбоо, дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээний ажил
- Явган хүний зам,
- Ногоон байгууламж







# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

